




ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮАГ-ын 2017 оны бүтээгдэхүүн ажил
үйлчилгээний төлөвлөгөө, нэгдсэн удирдамжийн
дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”



**Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д хамаарах
байгууллагуудын хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.**

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 дугаар сарын 17

№ А/24

Дархан-Уул аймаг

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 9.2, 2017 оны А/188 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Эрдэнэбат, Засаг дарга С.Насанбат нарт хүргүүлж, тайланд дурьдагдсан зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Х.Сувдмаад үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЧҮЛТЭМБАТ



D:\AJIL\bichig hereg\TUSHAAL.docx

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт.....2 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй....3-4
ААГ-ын НА-ын баг	БҮЛЭГ-1
Газрын дарга, тэргүүлэх аудитор	1. Үндсэн мэдээлэл.....5 1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3, 3.1.5-д заасан байгууллагуудын 100 хувь хамрагдлаа.....5
Ч.Чүлтэмбат	1.2. Байгууллагууд шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан ажилласан байна.....5
Аудитын менежер	БҮЛЭГ-2
Ш.Мөнхбаяр	2.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг 96 хувь нь мэдээлсэн байна.....6
С.Санжаажав	2.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1,3.1.2-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4 заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.....7
Аудитор	2.3.Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8 заасан мэдээллийг 93,3 хувьтай мэдээллэсэн байна.....8
2017 оны 11 дүгээр сар	2.4. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т заасан байгууллагууд төсвөөс авсан санхүүжилтийн 92,9 сая төгрөгийг дутуу мэдээллэсэн байна.....8-9
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7037-8845, 7037-8142 дугаарын утсаар харилцана уу.	БҮЛЭГ-3
ХАЯГ:	3.1.Сумдын ИТХ шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна..10
Дархан-Уул аймгийн Дархан сум 14-р баг Аймгийн ЗДТГ-ын байр 305 тоот	3.2.ТЕЗ-ын дотоод хяналтаар 47 байгууллагын төсвийн шууд захирагч нарт сахилгын шийтгэл ногдуулсан байна.....10-11
Аймгийн аудитын газар	3.3. ТЕЗ-ийн үр дүнгийн гэрээний тусгай захиалгат ажил үйлчилгээ хэсэгт шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг тусгасан байна.....11
	3.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явцад иргэд хяналт тавьж чадахгүй байна... 11-12
	БҮЛЭГ-4
	4.1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.....12
	4.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.....12
	БҮЛЭГ-5
	5.1. ДҮГНЭЛТ.....13
	5.2. ЗӨВЛӨМЖ.....13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

YAГ		Үндэсний аудитын газар
НАГ		Нийцлийн аудитын газар
АДБОУС		Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТӨХ		Төрийн өмчит хуулийн этгээд
ОНӨХЭ		Орон нутгийн өмчит хуулийн этгээд
ОНӨААТҮГ		Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ		Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТӨҮГ		Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨААТҮГ		Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХК		Хувьцаат компани
ТӨХК		Төрийн өмчит хувьцаат компани
НААҮГ		Нийтийн аж ахуй үйлчилгээний газар
ХААИС		Хөдөө аж ахуйн их сургууль
УГТСЭШХ		Ургамал газар тариалан сургалт эрдэм шинжилгээний хүрээлэн
ШУТИС		Шинжлэх ухаан технологийн их сургууль
ТЕЗ		Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ		Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АШУҮИС		Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ЗДТГ		Засаг даргын тамгын газар
ЭМТ		Эрүүл мэндийн төв
НХҮХ		Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс
ОНХС		Орон нутгийн хөгжлийн сан
ХАА		Худалдан авах ажиллагаа

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу аудитыг хийлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд, төрийн байгууллагыг 2015, 2016 онуудад хийсэн аудитын дүн, 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны шилэн дансны хэрэгжилтийг хамруулж гүйцэтгэлээ.

Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго:

Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршив.

Арга зүй:

Аудитыг АДБОУС 100-400, 4200, төрийн аудитын байгууллагын нийцлийн аудитын түр журам, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан шинэчилсэн журам
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Үндсэн мэдээлэл:

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийг тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн.

Аймгийн хэмжээнд шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах 126, 3.1.2-д хамаарах 1, 3.1.3-д хамаарах байгууллага 5, 3.1.5-д хамаарах 29, нийт 161 байгууллага, аж ахуй нэгж байгаагаас 160 нь шилэн дансны нэгдсэн сайтад бүртгэлтэй, холбогдох мэдээллээ байршуулж байна.

БҮЛЭГ 1

Шилэн дансны цахим хуудсанд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагуудын 100 хувь хамрагдлаа.

Оршил:

Дархан-Уул аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарагдах 161 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй, мэдээллээ байршуулж байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Шилэн дансны тухай хуулийн 3.1-д хамаарах хуулийн этгээд	Тоо
1	Хуулийн 3.1.1-д хамаарах /ТӨХЭ, ОНӨХЭ, ОНӨААТҮГ, ОНӨҮГ /	126
2	Хуулийн 3.1.2-д хамаарах / ТӨҮГ, ТӨААТҮГ /	1
3	Хуулийн 3.1.3-д хамаарах / ХК, ТӨХК /	5
4	Хуулийн 3.1.5-д хамаарах / Хувийн өмчийн сургууль, цэцэрлэг /	29
	Нийт дүн	161

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3, 3.1.5-д заасан байгууллагуудын 100 хувь нь хамрагдлаа.

1.1. Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-д хамаарах 132, 3.1.5-д хамаарагдах 29 байгууллага хамрагдлаа.

Харин 3.1.4-т хамаарах хуулийн этгээд байхгүй болно.

Байгууллагууд шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан ажилласан байна.

1.2. Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд шилэн дансны цахим хуудсанд тавигдах шаардлага, нийтлэг стандарт, агуулга, мэдээллийг иргэд, олон нийтэд хэрхэн хүргэх талаар хуульчилж өгсөн байдаг.

Хуулийн 3 дугаар зүйлд хамаарах хуулийн этгээд шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7¹, 5.8²-д заасны дагуу мэдээллийн ил тод байдлын самбараар төсөв, санхүүгийн мэдээллээ иргэдэд хүргэж байна.

¹ Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна.

² Мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

БҮЛЭГ 2

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8¹-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлэхгүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг дунджаар 96 хувьтай мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуульд мэдээллийг үнэн зөв, бодитой, тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээллэхээр хуульчилж өгсөн. Үүний дагуу хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын 2016 оны 4-р улирал, 2017 оны 1-3 дугаар улиралаар тасалбар болгон шалгахад дараах байдалтай байна.

2.1. Төрийн болон орон нутгийн өмчит 127 байгууллага аудитад хамрагдсанаас Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1³-д заасан тухайн жилийн батлагдсан төсвийг 1 нь буюу 0,8 хувь, ХАА-ны төлөвлөгөөг 2 буюу 1,6 хувь нь мэдээллээгүй бол ОНХС-ийн төлөвлөгөөг 100 хувь мэдээлжээ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2⁴-т заасан төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 127 байгууллагаас дундажаар 2 нь буюу 1,6 хувь нь мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3⁵-д заасан дараа жилийн төсвийн төслийг мэдээлбэл зохих 127 байгууллагаас 21 нь буюу 16,5 хувь нь мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4⁶-т заасан хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг мэдээлбэл зохих 127 байгууллагаас хагас жилийн санхүүгийн тайланг 4 нь буюу 3 хувь нь, бүтэн жилийн санхүүгийн тайланг 3 нь буюу 2,3 хувь нь мэдээлээгүй байв.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5⁷-т заасан ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлбэл зохих 127 байгууллагаас 1 нь буюу 0,8 хувь нь, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг 42 нь буюу 33,1 хувь нь мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6⁸-д заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг мэдээлбэл зохих 127 байгууллагаас 21 нь буюу 16,5 хувь нь мэдээлээгүй байна.

Өмнөх аудитаар хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээлэлийг 90,7 хувь нь мэдээлсэн бол тус аудитаар 96 болж 5,3 хувиар өссөн дүнтэй байлаа.

³ Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

⁴ Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор

⁵ Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор

⁶ Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор

⁷ Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухай жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор

⁸ Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4 заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

2.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд 6.4–т заасан мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасны дагуу шалгахад дараах байдалтай байв.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁹, 6.4.2¹⁰, 6.4.3¹¹-д заасан мэдээллүүдийг мэдээлбэл зохих 127 байгууллага 100 хувь мэдээлжээ.


Харин хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4¹²-т заасан 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 11129,5 сая төгрөгийн 350 гүйлгээнээс 1744,5 сая төгрөгийн 60 гүйлгээг мэдээлээгүй байв.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5¹³-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс авсан лавлагаатай тулган шалгахад 998,4 сая төгрөгийн зарлагын 64 гүйлгээ, 5189,9 сая төгрөгийн орлогын 95 гүйлгээг мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6¹⁴, 6.4.7¹⁵-д заасан мэдээллүүдийг мэдээлбэл зохих 127 байгууллага 100 хувь мэдээлжээ.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8¹⁶-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 15684,9 сая төгрөгийн 844 шийдвэрээс 857,0 сая төгрөгийн 184 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Өмнөх аудитын дүнтэй харьцуулбал зөрчлийн дүн 496,3 саяаар өссөн үзүүлэлтэй байна.



Шалгалтаар илэрсэн дээрх зөрчлөөс 22 байгууллагатай холбоотой 748,1 сая төгрөгийн зөрчлийн аудитын явцад арилгуулав.

⁹ Тухайн жилийн төсөөт орсон нэмэлт, өөрчлөлт

¹⁰ Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт

¹¹ Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан

¹² Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг

¹³ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр

¹⁴ Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн

¹⁵ Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт

¹⁶ Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8 заасан мэдээллийг 93,3 хувьтай мэдээллэсэн байна.

2.3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах 5 байгууллагаас 6 дугаар зүйлийн 6.8.1¹⁷, 6.8.2¹⁸-д заасан худалдан авах ажиллагааны тайлан, 6.10¹⁹-д заасан мэдээллүүдийг бүрэн байршуулсан.

Харин “Дархан-Ус суваг” ХК хуулийн 6.8.2-т заасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг, “Дулаан шарын гол” ТӨХК хуулийн 6.8.2-т заасан тендер, худалдан авалтын ерөнхий мэдээлэл, 6.8.3-т заасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалтын шийдвэрийг тус тус мэдээлээгүй байв.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т заасан байгууллагууд төсвөөс авсан санхүүжилтийн 92,9 сая төгрөгийг дутуу мэдээллэсэн байна.

2.4. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т хамаарах хувийн хэвшлийн 29 сургууль цэцэрлэг байгаагаас шилэн дансны нэгдсэн сайтад цэс нь нээгдсэн 28, цэс нээгдээгүй 1 байгууллага байна.

Дээрх хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгт 2016 оны 4-р улиралд 351,3 сая, 2017 оны 1-3 дугаар улиралд 1014,2 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Тус аудитаар 8 байгууллага нь 80.1 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй бөгөөд зөрчлийн хэмжээ өмнөх оноос 57.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	2017 оны 1-3 дугаар улирлын байдлаар /сая.төг/		Зөрүү
		Олгосон санхүүжилт	Мэдээлсэн	
1	Монгол оюу	58,2	49,9	8,3
2	19 дүгээр сургууль	101,9	87,4	14,5
3	24-р сургууль	66,3	56,8	9,5
4	Гэгээн босоо унага цэцэрлэг	29,2	28,5	0,7
5	Цондоолой цэцэрлэг	11,6	0	11,6
6	Төгс-Ундраа цэцэрлэг	51,1	30,1	21,0
7	Номин-Эрдэнийн өргөө	43,4	28,9	14,5
Нийт дүн		361.7	281,6	80.1

Тус аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд мэдээг тогтоосон хугацаанд, үнэн зөв байршуулаагүй, хоцроосон зөрчил нийтлэг ажиглагдлаа. Эдгээр нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1²⁰, 4.1.3²¹-д заасан хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчимтай нийцэхгүй байна.

¹⁷ Тухайн байгууллагатай холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр

¹⁸ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан

¹⁹ “..., Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна”

²⁰ Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

²¹ Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх

Тус аудитаар Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1²²-д заасны дагуу 23-н байгууллагын нягтлан бодогч нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөгдсөн. Хавсралт № 1-д үзүүлэв

²² Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна

БҮЛЭГ 3

*ТЕЗ-ын дотоод хяналтаар 47 төсвийн шууд захирагчид
сахилгын шийтгэл ногдуулсан байна.*

Сумдын ИТХ-аас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²³-д заасны дагуу аймгийн ИТХ, Төрийн аудитын байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг тавьж зөрчил гаргасан байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцон ажиллаж байна. Харин Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын ИТХ-аас хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

ТЕЗ-ын дотоод хяналтаар 47 байгууллагын төсвийн шууд захирагч нарт сахилгын шийтгэл ногдуулсан байна.

3.2. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2²⁴-д заасны дагуу шилэн дансы үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлж байна.

Тус албанаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2017 оны 1, 2 дугаар улирлыг хамруулан шалгасан байна. Шалгалтаар хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг байршуулахдаа хугацаа хоцроосон, 2 дугаар улирлын тайланг илгээгээгүй 47 байгууллагын төсвийн шууд захирагч нарт аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/419-н тоот захирамжаар 1 сарын үндсэн цалингийн 10 хувиар сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Хүнэгтгээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Шууд захирагчийн нэр
1	Аймгийн ЗДТГ	Ч.Энхбат
2	Захирагчийн алба	Э.Равжаадэлгэрэх
3	Орон нутгийн өмчийн газар	П.Батсүх
4	Ахмадын хороо	Д.Энхтайван
5	Нийтийн аж ахуй үйлчилгээний газар	Ж.Дорждэрэм
6	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар /ХЭДС/	С.Энхболд
7	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	А.Амгалан
8	Дархан барилга захиалагч ОНӨҮГ	Н.Батсайхан
9	Номын сан	Д.Цэрэндаваа
10	Музей	Д.Жамбалдорж
11	Мэдээлэл технологийн алба	С.Баяраа
12	10-р цэцэрлэг	С.Алтанчимэг
13	1-р сургууль	С.Баттулга
14	4-р сургууль	Н.Сүхбаатар
15	9-р сургууль	Т.Орхонтуяа
16	15-р сургууль	Ж.Насанжаргал
17	18-р сургууль	Н.Майцэцэг
18	Энэрэл цогцолбор	Д.Оюунцэцэг

²³ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ

²⁴ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ

19	Жигүүр цогцолбор	Б.Давааням
20	Оюуны ирээдүй цогцолбор	А.Нарантуяа
21	4-р цэцэрлэг	Д.Гэрэлт-од
22	5-р цэцэрлэг	О.Дэлгэрсайхан
23	13-р цэцэрлэг	С.Жаргалмаа
24	18-р цэцэрлэг	Ж.Дэжидмаа
25	21-р цэцэрлэг	Ш.Ундармаа
26	22-р цэцэрлэг	М.Уранчимэг
27	23-р цэцэрлэг	Н.Тунгалаг
28	3-р цэцэрлэг	Д.Эрдэнэчимэг
29	7-р цэцэрлэг	О.Энхжаргал
30	8-р цэцэрлэг	Г.Энхтулга
31	6-р цэцэрлэг	Д.Наранчимэг
32	11-р цэцэрлэг	Л.Соёлмаа
33	24-р цэцэрлэг	Л.Сувданчимэг
34	30-р сургууль	Ш.Ядамсүрэн
35	25-р цэцэрлэг	С.Хишигсүрэн
36	Шарын гол сумын 19-р цэцэрлэг	Х.Оюун
37	Шарын гол сумын 17-р цэцэрлэг	Д.Оюунцэцэг
38	Шарын гол сумын 2-р сургууль	Б.Батбаяр
39	Шарын гол сумын 6-р сургууль	Б.Ганбаяр
40	Шарын гол сумын 2-р цэцэрлэг	С.Болортуяа
41	Орхон сумын 8-р сургууль	О.Чимэдцэрэн
42	Орхон сумын 9-р цэцэрлэг	Х.Батаа
43	Хонгор сумын 14-р сургууль	Б.Төгсжавхлант
44	Хонгор сумын 11-р сургууль	З.Чулуунцэцэг
45	Хонгор сумын 16-р цэцэрлэг	Т.Оюунчимэг
46	Насан туршийн боловсрол төв	Т.Мэдэгсүрэн
47	Биеийн тамир спортын газар	Н.Батлав

Үр дүнгийн гэрээний тусгай захиалгат ажил үйлчилгээ хэсэгт Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг тусгасан байна.

3.3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах 127 байгууллагын 73 нь аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулдаг байна. Аймгийн Засаг дарга жил бүр үр дүнгийн гэрээний тусгай захиалгат ажил үйлчилгээнд тусгах арга хэмжээг баталдаг бөгөөд тус арга хэмжээнд шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар тусгайлан оруулж өгсөн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явцад иргэд хяналт тавьж чадахгүй байна.

3.4. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1²⁵-д иргэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтанд тавих, хүлээн аваагүй тохиолдолд төрийн аудитын байгууллагад хуулийн дагуу өргөдөл, гомдол гаргахаар заасан. Гэвч Шилэн дансны тухай хууль, цахим хуудасны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас шилэн дансны мэдээллийг ашиглаж, хяналт тавьж чадахгүй байна. Тухайлбал:

²⁵ Энэ хуулийн хэрэгжилтийн явц, шилэн дансны мэдээллийн зөрчил, дутагдал болон шаардлагыг байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу төрийн аудитын байгууллагад гаргах бөгөөд энэ хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын үйл ажиллагаанд аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргаж болно

Байгууллагынхаа Facebook хаягаар “Иргэн та төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын төсөв, санхүүгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн сайт www.Shilendans.gov.mn-наас авч, ашиглаж байсан уу” гэсэн асуулга явуулахад нэг ч иргэн хариулаагүй байна.

Иймд иргэдэд Шилэн дансны тухай хууль, нэгдсэн цахим хуудасны талаар ойлголт өгөх, хуульд заасан төрийн байгууллагаас гадна иргэд хяналт тавих, шаардах эрхтэй гэдгийг нь мэдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

БҮЛЭГ 4

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжилт хангалтгүй байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага бүрэн хэрэгжсэн байна.

4.1. Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй 6 байгууллагын нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн бөгөөд тус байгууллагуудаас сахилгын шийтгэл ногдуулсан тушаалыг нь авч баримтжуулсан болно.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2. Өмнөх аудитаар аймгийн Засаг дарга С.Насанбатад дараах зөвлөмж өгөгдсөн байна.

Зөвлөмж: Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагуудад санхүүжилт олгохдоо шилэн дансны мэдээллээ бүрэн байршуулсан эсэхийг харгалзан үзэж байх.

Зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажил:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. Тухайлбал: Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч Монгол оюу, 19 дүгээр сургууль, 24-р сургууль, Гэгээн босоо унага цэцэрлэг, Цондоолой цэцэрлэг, Төгс-Ундраа цэцэрлэг, Номин-Эрдэнийн өргөө цэцэрлэгүүд нь төсвөөс авсан санхүүжилтээ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй байна.



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

45059 Дархан, Дархан-Уул аймаг, 14 дүгээр баг
Утас/Факс: 7037-7880
Web: darkhan-uul.khural.mn

2017.11.17 № 289
танай 2017.11.17, -ны № 300 -Т


АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д
хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

ДАРГА

Г.ЭРДЭНЭБАТ



Салхи оо шавь
2017.11.17

D:/toot1.docx

БҮЛЭГ 5**АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ****ДҮГНЭЛТ**

5.1. Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээлэлийг 96 хувьтай мэдээлсэн нь өмнөх оноос 5,3 хувиар өссөн ч хугацаа хоцроож мэдээлсэн нийтлэг зөрчил их байна.
2. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлэхгүй байна.
3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
4. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэд мэдлэг, мэдээлэл дутмаг байна.
5. Сумдын ИТХ-аас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.

ЗӨВЛӨМЖ

5.2. Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга С.Насанбатад зөвлөж байна.

1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагуудад санхүүжилт олгохдоо шилэн дансны мэдээллээ бүрэн байршуулсан эсэхийг харгалзан үзэх.
2. Шилэн дансны тухай хуулийг сурталчлан, биелэлтийг нь хангах ажлыг зохион байгуулах
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 03 дүгээр сарын 01-ны дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.3. Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын ИТХ-ын дарга нарт зөвлөж байна:

1. Шилэн дансны тухай хуулийн 8-р зүйлд заасны дагуу хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР